



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№56 /270/

2022.03.22

Цаг үе, үйл явдал

ШИЛДЭГ СОНСОГЧ, СУРАГЧИД ШАГНАЛ ГАРДУУЛАВ



“Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шагнал хүртээх журам”-ын болзол хангасан шилдэг сонсогч, сурагчид шагналаа гардаг авлаа. Тодруулбал, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Ерөнхий цэргийн 4 дүгээр дамжааны сонсогч

Н.Дашзэвэг, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн 641 дүгээр дамжааны сонсогч Б.Марал-Эрдэнэ, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Тэмүүжин өрлөг” дунд сургуулийн 12 дугаар ангийн сурагч О.Шаравжамц нар тус шагналыг хүртсэн юм. Эдгээр сонсогч, сурагч

нар сурлагаараа бусдыгаа манлайлан, эрдэм шинжилгээний ажил, уралдаан, тэмцээнд идэвхтэй оролцож, цэргийн тангараг, дүрмийн шаардлагыг чанд сахин биелүүлж, сахилга бат, хариуцлага, хандлага, бие бялдар, ёс зүйн зөв төлөвшил эзэмшжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -17


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,925.00	2,930.0
EUR 🇪🇺	3,300.0	3,340.0
CNY 🇨🇳	467.50	470.00
RUB 🇷🇺	29.50	31.00
JPY 🇯🇵	25.20	25.50
KRW 🇰🇷	2.45	2.47

ЗУРХАЙ




2022.03.22, МЯГМАР ГАРАГ, БИЛГИЙН ТООЛЛЫН 19

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.51-19.07
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй
Суудал: Мод

Өдрийн наран 6 цаг 51 минутад мандан, 19 цаг 07 минутад жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, лус тахих, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирх” хэмээх сайн.



МЕНИНГИТ ӨВЧИН

МЭНГИТ ӨВЧИН ТЭМЦЭГ	СРЬЛЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРТЭСӨД
СЭГТ ӨДӨР ХАЛДВАР	НАРЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
СЭВЭГНИЙ	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
ИЭРЧ	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
ХӨРӨГӨД, ОХИД, ХӨДӨГ	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
ЦЭВЭР	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
ТӨГӨХ ҮС МӨӨР ХҮСЭН	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.
ХӨДӨГ СЭРГИЙН	МОНГОЛ УЛСЫН ХАМГААЛАХ БУСДЫГАА МАНЛАЙЛАН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, УРАЛДААН, ТЭМЦЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЦЭРГИЙН ТАМГАРАГ, ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ ЧАНД САХИН БИЕЛҮҮЛЖ, САХИЛГА БАТ, ХАРИУЦЛАГА, ХАНДЛАГА, БИЕ БЯЛДАР, ЁС ЗҮЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛ ЭЗЭМШЖЭЭ.

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦУГЛАРАЛТ ЭХЭЛЛЭЭ



Нийслэл, дүүрэг, 21 аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалт өнөөдөр Батлан хамгаалах яамнаа эхэллээ. Нийслэл, дүүрэг, аймгуудын Цэргийн штабын дарга нарын цугларалтыг 2017 оноос эхлэн 5 дахь жилдээ зохион байгуулж байна. “Батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудал” сэдэвт энэ удаагийн цугларалтын зорилго Цэргийн штабын дарга нарын батлан хамгаалах бодлогын шинэчлэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, түүнийг орон нутагт хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа юм.

Цугларалтын нээлтэд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал болон нийслэл, дүүрэг, аймгуудын Цэргийн

штабын дарга нар оролцлоо.

Бригадын генерал Д.Ганхуяг цугларалтыг нээж “Энэ удаагийн цугларалтын хүрээнд явагдах асуудал арга хэмжээ нь Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудын үйл ажиллагааны хөгжил, төлөвшил, орон нутаг дахь батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, та бүхнийг шинэ мэдээ мэдээллээр хангасан, харилцан туршлага солилцсон чухал ач холбогдолтой болно гэдэгт итгэлтэй байна. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, батлан хамгаалахын багц хуулиуд батлагдсанаас хойших хугацаанд шинэчлэгдэн батлагдсан хуулиудад нийцүүлэн батлан хамгаалах эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан, хэрэгжүүлж байна. Ялангуяа орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, дайчилгааны бэлтгэлийг

хангах, явуулахтай холбоотой бүхий л дүрэм, журам, норм, жагсаалтуудыг боловсруулан баталгаажуулж дууссан. Дээрх шинэчлэгдсэн эрх зүйн баримт бичгүүдийг та бүхэн өдөр тутмын ажил, албандаа байнга дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, сурталчлах ёстой” хэмээгээд цугларалтад оролцогсод амжилт хүсэв. Мөн тэрээр Батлан хамгаалахын сайд Цэргийн штабуудын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг санаачилж, тодорхой үе шаттай хэрэгжүүлж байгаа, та бүхэн үүнийг улам төгөлдөржүүлэх ёстой. Ингэснээр цаг хэмнэх, түргэн шуурхай байх, хүнд суртал арилах зэрэг ач холбогдолтой гэдгийг онцлов.

Энэ үеэр бригадын генерал Ч.Цогтжаргал ЗХЖШ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоо” бодлогын талаар танилцууллаа. Мөн хурандаа Ч.Гандирваа бие бүрэлдэхүүнд хандан

үг хэлж, зарим үүрэг чиглэлийг өгөв.

Цугларалтаар орон нутаг дахь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, нийслэл, дүүрэг, аймгуудын ЗДТГ-ын Цэргийн штабуудын өнгөрсөн оны ажлыг дүгнэн, энэ онд дэвшүүлсэн зорилго, зорилт, хийж хэрэгжүүлэх ажил, үйл ажиллагааг хэлэлцэхийн зэрэгцээ шинээр батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, сургалт бэлтгэл, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар цугларалтад оролцож байгаа бүрэлдэхүүнд мэдээлэл өгч, харилцан санал солилцоогдох юм.

“Батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудал” сэдэвт цугларалт энэ сарын 22-28-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон Дорнод аймагт явагдах юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,204 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,172 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,030,410 31,7% 112,360 /3,5%/
НИЙТ БАТЛАГДСАН 8430 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 6	ЭДГЭРСЭН 8304

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 472,646,819

Эдгэрсэн

Нийт: 408,583,119

Нас барсан

Нийт: 6,105,622

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРӨӨР ...

АЛБА ХААГЧДЫГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН МЕДАЛИАР ШАГНАЛАА



Зэвсэгт хүчний 101 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар эрхэлсэн ажил албандаа олон жил үр бүтээлтэй ажилласан, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хөгжил дэвшилд онцгой

хувь нэмэр оруулсан зарим алба хаагчдыг цэргийн гавьяаны одон медалиар шагналаа.

Энэхүү хүндэтгэлийн үйл ажиллагааг нээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо үг хэлж, амжилт

бүтээлээ үнэлүүлэн шагнал хүртэж буй бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, амжилт хүсэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор Батлан хамгаалахын төв архивын дарга асан бэлтгэл хурандаа З.Эрдэнэбат, Цэргийн УТХАНэгдсэн эвлэлийн удирдах зөвлөлийн гишүүн бэлтгэл хошууч Ч.Цэенбалжир, чөлөөнд байгаа дэд хурандаа Н.Цэвээнжаргал, бэлтгэл дэд хурандаа М.Бямбарагчаа, А.Хүнбиш нар, Цэргийн гавьяаны одонгоор чөлөөнд байгаа дэд хурандаа Г.Гонгор, О.Бямбадорж, чөлөөнд байгаа хошууч Д.Сэндoo, ахмад С.Бямбачулуун, бэлтгэл хошууч Д.Баярсайхан нарын ахмадууд, Цэргийн хүндэт медалиар чөлөөнд байгаа ахлах ахлагч С.Саранцэцэг, М.Сүдбаатар, ахлагч Н.Бат-Очир, Б.Эрдэнэ нарын 30 гаруй алба хаагчдыг шагнасныг өнөөдөр гардуулан өгсөн юм.

ЦДБЭЧ-ЫН УРАН БҮТЭЭЛЧДЭД ШАГНАЛЫН ХҮР БУУЛАА

Зэвсэгт хүчний 101 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан эрхэлсэн албандаа олон жил үр бүтээлтэй ажилласан ЦДБЭЧ-ын зарим офицер, ахлагч,

"Жуух бичиг"-ээр бүжигчин ахлагч Б.Мөнхбаатар, гоцлол хөгжимчин А.Батцоож, ЗХЖШ-ын "Хүндэт өргөмжлөл"-өөр дуучин ахлагч Н.Түвшинжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын

ээр Б.Бямбадорж, Н.Цолмон, Д.Энхбаяр нар, Соёлын яамны сайдын тушаалаар "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр Удирдаач ахлах дэслэгч С.Сэргэлэн, гоцлол дуучин ахлагч Г.Мөнхбат, дуучин ахлагч Б.Жаргалтогтох, хөгжимчин ахлагч Д.Өлзийбаяр нар, Соёлын яамны "Жуух бичиг"-ээр гоцлол бүжигчин ахлагч А.Энхжаргал, гоцлол хөгжимчин ахлах ахлагч Б.Пунцагдаш, дуучин ахлагч Д.Лхамхүү, дуучин С.Бүрэнжаргал нар шагнагдсаныг чуулгын удирдлага гардуулан өгч баяр хүргэлээ.



Түүнчлэн Монголын залуучуудын холбооны "Хөдөлмөрийн алдар" алтан медалиар гоцлол дуучин ахлагч Д.Алтанхүү, Г.Дөлбадрах, дуучин ахлагч Н.Түвшинжаргал нарыг шагнасныг МЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Цэнд-Аюуш гардуулан өгч баяр хүргэсэн юм. Чуулгын даргын тушаалаар Найрал дууны албаны гоцлол

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчний түүхт 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын цэргийн тангараг давтах, нэгдсэн тооллого явуулах цуглааны үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар мэндчилгээ дэвшүүлэн баяр хүргэв. Энэ үеэр тус ангиас цэргийн тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчид, ажилтан албан хаагчдаа хүндэтгэл үзүүлсэн юм.

Мөн зарим цэргийн алба хаагчдад Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын болон ХЗЦ-ийн командлагчийн тушаалаар цэргийн цол, салбарын бусад шагнал, тус ангиас цэргийн тэтгэвэрт гарсан алба хаагчдад дурсгалын зүйлсийг тус тус гардуулж өгөв. Арга хэмжээний төгсгөлд бэлтгэл дэд хурандаа П.Цэрэндорж шагнал хүртсэн бие бүрэлдэхүүнд болон ангийн нийт бие бүрэлдэхүүнд баяр хүргэж үг хэлсэн юм. Үүний дараа ахмад дайчдад зориулсан хүндэтгэлийн цэнгүүнийг зохион байгууллаа.

Дэслэгч Р.БИЛЭГ

БИДЭНД ЗАХИДАЛ ИРЛЭЭ

Тус ангийн ИСБ-ны Инженер сапёрын ротын байлдагч Н.Наран-Очирын гэр бүлээс ирүүлсэн мэндчилгээг та бүхэнд хүргэхэд таатай байна.

"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчний түүхт 101 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хугацаат цэргийн алба хаагчдын ар гэр, ах дүүс та бүхэнд байлдагч Н.Наран-Очирын гэр бүлээс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье. Миний зээ хүү Н.Наран-Очир эр цэргийн эгнээнд жагсаж, эх орны хүү болон төлөвшиж байгаад эмээ өвөө, ах дүүс нь магнай тэнийн баярлаж байна. Эмээ өвөө хоёр нь насаараа боловсролын байгууллагад зүтгэсэн ахмад багш нар. Тийм болохоор аав ээжийн энэ олон хөвгүүдийн оюун ухаан цэлмэг байхыг бэлгэцгээж танай хамт олонд дэлхийн болон монголын шилдэг 100 гаруй номыг бэлэг болгон барьж байна. Монголын түүхэн сэдэвт "Монголчууд"



цуврал ботиос эхлээд Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, Д.Намдаг, Ж.Пүрэв, Ч.Лхамсүрэн нарын шилдэг бүтээл, "Эрдэнийн сан Субашид", "Эзэн Чингис хаан", "Ардын журамт цэргийн дурдатгалууд", Зөвлөлтийн нэрт зохиолч Чайковскийн "Ялалт" боть, "Зөвлөлтийн зохиолчдын шилдэг түүжис" зэрэг олон сайхан ном бий. "Эрхэм баян эрдэнэт ном" гэсэн эцэг өвгөдийн мэргэн сургаалыг эрхэмлэн дээдэлж явахыг байлдагч хөвгүүддээ

ерөө! Дайчин уламжлалт танай хамт олон, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний оюуны мэлмий тунгалаг байж, номын цагаан буян тань дэлгэрэх болтугай. Хүндэтгэсэн: Өвөө Ардын боловсролын тэргүүний ажилтан, Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч тэргүүний ажилтан Лха.Ганболд, Эмээ: Ардын боловсролын тэргүүний ажилтан, Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч тэргүүний ажилтан Ж.Оюун

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

ЭРДЭНЭТ ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ АВАРГУУДААР...



"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 101 жил, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан Эрдэнэт цэргийн хүрээний аварга шалгаруулах цогцолбор тэмцээн дөрөв хоногийн турш өрнөж аваргуудаа тодрууллаа. Уг тэмцээнд Орхон, Булган аймгийн 16 багийн 200 гаруй баг тамирчин оролцож сагсан

бөмбөг, гар бөмбөг, олс таталт, модон морин дээгүүр харайх, шатар гэсэн спортын 5 төрлөөр өрсөлдсөн юм.

Тэмцээний нийлбэр дүнгээр I байрт хурандаа Ц.Амарсайхан захирагчтай Зэвсэгт хүчний 110 дугаар анги, II байрт Г.Ганбаатар даргатай Орхон аймгийн ОБГ, III байрт хурандаа Д.Жигжидсүрэн захирагчтай Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн баг тамирчид тус тус шалгарлаа.

12 НЭР ТӨРЛИЙН ХООЛООР ҮЙЛЧИЛЛЭЭ

Цэргийн гал тогооны хамт олон иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Орхон аймаг дахь Тогооч нарын холбооны "Залуу тогооч" клубтэй хамтран 3 дугаар сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийн баярын арга хэмжээнд зориулж 12 нэр төрлийн хоол, салат зууш бэлтгэн үйлчиллээ.



Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ